210301	Гэрэл, цахилгаан	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,262,560.00
210402	Тээвэр, шатахуун	1,262,560.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	118,055,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	117,515,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	540,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>29,937,246.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	11,068,500.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	18,868,746.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	168,886,060.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	168,886,060.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	156,602,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,443,560.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,840,000.00
131106	Төсвийн урамшуулал	
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>18,868,746.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,868,746.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Баян-Агт сум ТТЗ нь 2022 оныг "Эмх цэгц дэг журмыг сахих ба сахиулах жил" болгон зарлаж "Иргэдээ дээдэлсэн ухаалаг үйлчилгээг нэвтрүүлэх" гэсэн зорилт тавин ажиллажээ.

Мөн сумын төсөвт байгууллагуудын төсвийн орлого зарлага зарцуулалтын үйл ажиллагаа, төрийн болон орон нутгийн өмчийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих удирдлагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх бодит мэдээ мэдээллээр хангах зорилгыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Сумын хэмжээнд 2022 онд аймгийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 93.7 хувиар, сумын засаг даргын мөрийн хөтөлбөр 85.8 хувиар тус тус биелсэн гүйцэтгэлтэй дүгнүүлжээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Архив бичиг хэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, НББ-ийн тухай хууль болон бусад тогтоол шийдвэрийг мөрдөн ажилласан байна.

Мөн Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн захирагч нарт төсвийг хэмнэлттэй зарцуулах үүрэг өгч ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Агт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, аймгийн Засаг даргын

2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Агт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3220017.8 мянган төгрөгөөр буюу 63.5 хувиар буурсан нь ЭМТ, Соёл, Сургууль Цэцэрлэгийн байгууллагууд орон нутагт нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	232.5	322.7	90.2
Авлага	434.8	215.9	218.9
Бараа материал	492.9	198.2	-294.7
Үндсэн хөрөнгө	5111.6	2314.9	-2796.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6271.9</b>	<b>3051.9</b>	<b>-3220.0</b>
Өр төлбөр	1.1	0.03	-1.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6270.8	3051.9	-3219
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>6271.9</b>	<b>3051.9</b>	<b>-3220.0</b>

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 294737.3, үндсэн хөрөнгө 2796618.4 мянган төгрөгөөр буюу нийт хөрөнгийн хэмжээ 3220017.7 мянган төгрөгөөр буурснаар тайлагнажээ.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 232533.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 322771.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаж 90237.5 мянган төгрөгөөр өссөн нь зээлийн эргэн төлөлтийн орлого орсонтой холбоотой байна.

#### Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө			
<b>Төгрөг</b>			
Төрийн сангийн харилцах	232.5	322.7	90.2
Арилжааны банк дахь харилцах			
<b>Гадаад валют</b>			
Арилжааны банк дахь харилцах			
Замд яваа мөнгөн хөрөнгө			
<b>Дүн</b>	<b>232.5</b>	<b>322.7</b>	<b>90.2</b>

Эх сурвалж: Мөнгөн хөрөнгийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 322771.5 мянган төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

#### Аудитын илрүүлэлт

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчил илрээгүй болно.

### 3.5.2 Авлага

Авлагын эхний үлдэгдэл 434835.4 мянган төгрөгийн, эцсийн үлдэгдэл 215935.9 мянган төгрөг болж 218899.5 мянган төгрөгөөр буурсан нь ЭМТ, Цэцэрлэг, Сургууль, Соёлын төв гэсэн байгууллагууд нь орон нутгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой байна.

#### Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	5.2	2.4	-2.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	178.7	0	-178.7
Татаас, санхүүжилтийн авлага		10	10
Зээлийн хүүгийн авлага	0	0	0
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/			0
Татаас, санхүүжилтийн авлага			
Байгууллагаас авах авлага	23.4	1.1	-22.3
Хувь хүмүүсээс авах авлага	227.5	202.4	-25.1
Дүн	434.8	215.9	-218.9

Эх сурвалж: Авлагын 2022 [оны санхүүгийн нэгтгэсэн тайлан](#)

Дээрх авлагаас ОХНС-д 47501.6, ХХС-гийн дансанд 125517.7, ЖДҮДС-гийн дансанд 25128.9, ЗДТГ-ын дансанд 17787.7 мянган төгрөгийн авлагууд тус тус эзэлж байна.

#### Аудитын илрүүлэлт

Авлагатай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа төлбөртэй холбоотой дансны авлага өглөг үүсээгүй болно.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 492972.6 мянган төгрөг, [эцсийн үлдэгдэл](#) 198235.3 мянган төгрөг болж, 294737.3 мянган [төгрөгөөр](#) буурсан нь ЭМТ, Соёл, Сургууль Цэцэрлэгийн байгууллагууд орон нутгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой байна.

#### Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>192.1</b>	<b>82.4</b>	<b>-109.7</b>
Тусгай зориулалттай материал	105.7	82.4	-23.3
Эм боох материал	86.4	0	-86.4
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>270.9</b>	<b>84.3</b>	<b>-186.6</b>
Бичиг хэргийн материал	10.8	3.6	-7.2
Аж ахуйн материал	206.7	13.5	-193.2
Сэлбэг хэрэгсэл	2.6	1.9	-0.7
Түлш, шатах тослох материал	0.03	0.03	0
Барилгын засварын материал	0	1.6	-1.6
Хүнсний материал	10.4	0	10.4
Бусад хангамжийн материал	39.9	63.4	-23.5
<b>Мал амьтад</b>	<b>30</b>	<b>31.6</b>	<b>-1.6</b>

<b>Дүн</b>	<b>492.9</b>	<b>198.2</b>	<b>-294.7</b>
------------	--------------	--------------	---------------

Эх сурвалж: Бараа материалын 2022 [оны санхүүгийн нэгтгэсэн тайлан](#)

Тайлант онд бараа материалыг төсвийн хөрөнгөөр 202464.4 мянган төгрөгийн материал худалдан авч, үнэ төлбөргүй буюу хандиваар 74902.4 мянган төгрөгийн бараа материалыг тус тус орлого авч тайлагнажээ.

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/194 тоот тогтоолоор цаашид ашиглах боломжгүй 6442.5 мянган [төгрөгийн](#) бараа материалыг акталж данс бүртгэлээс хассан байна.

#### Аудитын илрүүлэлт

Сумын ТТЗ-ийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар ОНХС-гаар бэлтгэсэн 7055.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн орлого аваагүй зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5111608.4 мянган төгрөг, [ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ](#) 2314990.0 мянган төгрөг болж, 2796618.4 мянган [төгрөгөөр](#) буурсан нь ЭМТ, Соёлын төв, сургууль, цэцэрлэг гэсэн төсөвт байгууллагууд салбар, салбарын нэгдсэн тайланд нэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>5007.4</b>	<b>2284.8</b>	<b>-2722.7</b>
Барилга, байгууламж, орон сууц	3755.6	1603	-2904.6
Авто-тээврийн хэрэгсэл	343.6	241.9	-101.7
Машин тоног төхөөрөмж(компьютер)	581.2	277.8	-303.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	264.3	99.4	-164.9
Бусад үндсэн хөрөнгө	62.7	62.7	0
Дуусаагүй барилга, байгууламж			
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>104.2</b>	<b>30.2</b>	<b>74</b>
Программ хангамж	3.5	0.5	-3
Бусад биет бус хөрөнгө	100.7	29.7	-71
<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>			
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/			
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад			
<b>Дүн</b>	<b>5111.6</b>	<b>2314.9</b>	<b>-2796.7</b>

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: Үндсэн хөрөнгийн 2022 [оны санхүүгийн нэгтгэсэн тайлан](#)

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2150.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 115188.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авч, УТХО-аар хэрэгжсэн ЗДТГ-ын барилгыг 799604.1 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй буюу хандиваар орлого авч нийт 1050327.2 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийг нэмэгдүүлж, 2796618.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хассанаар тайлагнасан нь эрүүл мэнд соёлын байгууллагууд нь харьяа салбартаа нэгтгэгдсэнтэй холбоотой байна.

Дуусаагүй барилга дансанд үлдэгдэл хөрөнгөгүй байна.

#### Аудитын илрүүлэлт:

Тус сумын 2022 оны ОНХС-гийн хөрөнгөөр худалдан авсан 3000.0 мянган төгрөгийн үнэтэй драйгерийг орлого авч тайлагнаагүй зөрчилд 1 албан шаардлага тогтоов.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эхний үлдэгдэл 1135.0 мянган төгрөгийн, эцсийн үлдэгдэл 33.5 мянган төгрөг болж, 1000.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татварын өглөг	0	0	0
Байгууллагад төлөх өглөг	0.5	0.03	-0.47
Ажилчидтай холбоотой өглөг	0.3	0	-0.3
Бусад	0.3	0	-0.3
Дүн	1.1	0.03	-1.07

Эх сурвалж: Өр төлбөрийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх өглөгийн үлдэгдэл нь сумын ЗДТГ-ын тайланд өглөгөөр тусгаж тайлагнасан дүн байна.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөртэй холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6270815.4, эцсийн үлдэгдэл 3051899.2 мянган төгрөг болж 3218916.2 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэнд, соёл, боловсролын байгууллагууд нь харьяа салбартаа нэгтгэгдсэн холбоотой байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2082.9	282.1	1800.8
Өмч /төрийн/ /ТӨҮГ/			
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2419.0</b>	<b>2581.9</b>	<b>-162.9</b>
Өмнөх үеийн үр дүн	2128.0	5754.6	-3626.6
Тайлант үеийн үр дүн	290.9	-3172.7	-3172.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1768.9	187.8	1581.1
Дүн	6270.8	3051.8	3219.0

Эх сурвалж: Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3051899.2 мянган төгрөг болж 3218916.2 мянган төгрөгөөр буурсан нь эрүүл мэнд, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагууд нь харьяа салбартаа санхүүгийн тайлангаа нэгтгүүлсэнтэй холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 187877.8 мянган төгрөг болж 1581053.8 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн байгууллагуудаас бусад байгууллагуудын хөрөнгийн дахин үнэлгээ салбарууддаа шилжиж тайлагнасантай холбоотой болно.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэлгүй болно.

Хуримтлагдсан үр дүн 3172716.9 мянган төгрөг болж 3463660.2 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэнд, соёл, боловсролын байгууллагууд нь харьяа салбартаа нэгтгэгдсэн холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 271100.0, орон нутгийн төсвөөс 77300.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1044500.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн VII хуралдаанд танилцуулсан байна.

Сумын хүргүүлсэн төсвийн төслийн нийт зардлын дүнг 721300.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1765800.0 мянган төгрөгөөр тодотгол хийж сумын ИТХ-д 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 03 тоот тогтоолоор өөрчилжээ.

Энэ нь ТҮ-1-3 шатлалаар цалинждаг гэрээт ажилчдыг орон нутгийн байгууллагад нэгтгэхээр шийдвэр гарч гэрээт ажилчдын цалин, НДШ, тогтмол зардал болон төрийн үйлчилгээний цэвэрлэгээний зардлуудыг нэмэгдүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зориулан 22 арга хэмжээнд 1765800.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1320500.0 мянган төгрөгийг урсгал зардалд, тогтмол зардалд 445300.0 мянган төгрөгийг зарцуулахаар тус тус төлөвлөн батлуулжээ.

Нийт зардлыг эх үүсвэр тус бүрээр харуулбал:

Орон нутгийн төсвөөс 1212528.0, орон нутгийн хөгжлийн сангаас 153208.4, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 63492.9, урьд оны үлдэгдлээс 209331.5 сая төгрөг буюу нийт 1638560.8 төгрөгийн санхүүжилт бүрдүүлэхээр батлуулсан байна.

Гүйцэтгэлээр 1262083.5 сая төгрөгийг улсын /орон нутгийн төсвөөс, 153208.4 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 85960.2 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос нийт 1347043.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч ажиллажээ.

Үндсэн үйл ажиллагааны орлого 437000.0 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 86400.0 мянган төгрөгөөр орлого дутуу бүрдүүлсэн нь малд ногдуулсан албан татвар болон ЖДҮДС, ХХС-гийн эргэн төлөлтийн авлага бүрэн ороогүйтэй холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлого ЗДТГ нь 300.0 мянган төгрөгөөр төлөвлөж орлогыг бүрэн оруулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл бодит зардлаар 1246922.3 мянган төгрөгийг зарцуулж 76 хувийн гүйцэтгэлтэй байна.

Баян-Агт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1638560.8 мянган төгрөг буюу 1246922.3 мянган төгрөгийг зарцуулж 237740.8 мянган төгрөгийг хэмнэжээ.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Здтг -Үндсэн үйл ажиллагаа	326.8	321.1	5.7	98.2
2	Баг хорооны засаг дарга	70.5	67.2	3.3	95.3
3	Нийтлэг үйлчилгээ	18.0	18.0	0	100
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж	22.2	20.3	1.9	91.4
5	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдөх	4.9	4.9	0	100
6	Бусад тоног төхөөрөмж	128.0	74.7	53.3	58
7	Орон нутгийн нөөц хөрөнгө	35.0	35.0	0	100
8	Хур хог хаягдал орчны бохирдол	4.0	4.0	0	100
9	Улсын баяр наадам	10.0	10.0	0	100
10	ИТХ -Үндсэн үйл ажиллагаа	82.5	82.5	0	100

11	Ажил олгогчоос олгох тэтгэмж	5.7	5.7	0	100
12	Багийн ИНХ даргын урамшуулал	0.8	0.8	0	100
13	Цэц -төрийн өмчийн барилгын тогтмол зардал	56.3	56.3	0	100
14	Нийтлэг үйлчилгээ	15.2	15.2		100
15	Сур -төрийн өмчийн барилгын тогтмол зардал	280.3	280.3		100
16	Нийтлэг үйлчилгээ	54.1	54.1		100
17	ЭМТ -төрийн өмчийн барилгын тогтмол зардал	52.1	52.1		100
18	ОНХС Итгэлцүүр	203.1	131.4	71.7	64.7
19	БХС Байгаль орчин нөхөн сэргээх	14.3	8.4	5.9	58.7
20	ХХС-эргэн төлөгдөх зээл	209.3	1.2	208.1	0.4
21	ЖДҮ сан	45.4	3.7	41.7	8.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн тайлангаар 187.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч гүйцэтгэлээр гэрэл цахилгааны зардалд 500.0, тээвэр шатахууны зардалд 1262.5, төлбөр хураамжийн зардалд 1000.0, бусад зардалд 118000.0, төвлөрүүлэн шилжүүлгийн зардалд 29937.2, тоног төхөөрөмжийн зардалд 37000.0 мянган төгрөгийг тус тус нэмэлт дансаар зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Агт сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Агт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/36 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баян-Агт сумын ТТЗ-ийн 2023 оны нийт санхүүжилтийн дүнгийн 2706713.4 мянган төгрөгөөс материаллаг байдлын түвшинг 1.5 хувь буюу 40600.7 мянган төгрөгийн 75 хувиар тооцон 30450.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсөвт байгууллагын орон тоог 5 ажилтнаар бууруулан ажиллаж, цалингийн зардлыг 12.0, НДШ-ийн зардлыг 3.2, бараа үйлчилгээний зардлыг 11.6, тэтгэмжийн зардлыг 18.9, зээл олголтын зардлыг 121.3 сая төгрөгөөр тус тус хэмнэжээ.

#### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлэх мэдээллүүдийг бүрэн мэдээлж ажиллажээ.

##### **4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэлийг түүвэрлэлтийн горим сорилоор шалгахад суманд орон сууц барих газарт 8-10м гүнд 2 цооног барих, хаус хороолол барих газарт 4-6м гүнд 3 цооног нийт 5 цооног өрөмдөх, магадлалаар орсон инженер геологийн дүгнэлтийг гаргуулах ажлыг 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдөр урьдчилгаа 500.0 мянган төгрөг өгөхөөр, нийт ажлын дүнг гэрээнд тусгаагүй, "Ленд талст" ХХК-тай гэрээ байгуулж урьдчилгаа болох 500.0 мянган төгрөгийг Баян-Агт хөгжил сангаас 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдөр 120101848434 тоот данснаас шилжүүлсэн, 2022 онд сумын ОНХС-гаас хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тус ажлыг нэмж оруулан баталж 2022 оны 12 дугаар сарын 20-нд Баян-Агт хөгжил сангийн данс руу 5000.0 мянган төгрөгийг шилжүүлж, Баян-Агт хөгжил сангийн дансанд 4500.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д

“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн:**

Төлбөрийн акт тогтоов.

Тус сумын ОНХС-гийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг түүвэрлэлтийн горим сорилоор малын тоо толгойн албан татвараас 287.2 мянган төгрөгийн шатахууны зардлыг даргын цохолтгүй, жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Төлбөрийн акт тогтоов.

Тус сумын ОНХС-гийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг шалгахад гэрээ байгуулсан гүйцэтгэгч нар гэрээнд тусгагдсан хугацаанд ажлаа дуусгаагүй, хугацаа хэтэрсэн, санхүүжилтийг олгохдоо 178.8 мянган төгрөгийн алданги тооцоогүй бүрэн олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, ажил гүйцэтгэх гэрээний 5 дугаар зүйлийн 3-д “гүйцэтгэгч ажлыг хугацаа хэтрүүлсэн бол хэтрүүлсэн хоног тутамд 0.1 хувийн алданги тооцож захиалагчид төлнө” гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Төлбөрийн акт тогтоов.

Тус сумын ОНХС-гийн хөрөнгөөс баяр наадмын зардалд 10000.0 мянган төгрөг зарцуулсныг горим сорилоор түүвэрлэн шалгахад 143.8 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Төлбөрийн акт тогтоов.

Тус сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 3000.0 мянган төгрөгийн үнэтэй драйгерийг орлогод аваагүй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1

“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Албан шаардлага хүргүүлэв.

Тус сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 7054.9 мянган төгрөгийн өвс тэжээлийг орлогод аваагүй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Албан шаардлага хүргүүлэв.

Тус сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг төлөвлөн батлуулж байгаа ч томилогдсон ажлын хэсгийн гишүүд ажлаа бүрэн хийдэггүй, тоног төхөөрөмж болон ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан ажил хангалтгүй, батлагдсан үнээр худалдан авалт хийгээгүй, цаад газраас үнийн санал авч ажиллаагүй нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1-д “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Албан шаардлага хүргүүлэв.

Сумын 2022 онд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжсэн 22 ажлаас өмнөх оны 6 ажлаас гадна 18 ажил гүйцэтгэхэд иргэд олон нийтээс санал аваагүй 7 ажлыг санхүүжүүлж ажилласан нь ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулах;”, 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 3-д “Иргэдээс авсан ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналын урьдчилсан жагсаалтыг бэлтгэж иргэдийн Нийтийн Хурал/цаашид ИНХ гэх/-д хүргүүлэх” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Зөвлөмж хүргүүлэв.

БХС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн шатахууны орлогыг, зарлагыг бараа материалын тодруулга тайланд тайлагнаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:  
Зөвлөмж хүргүүлэв.

ЖДҮДС-гийн зээлийн үлдэгдэлтэй иргэдтэй жилийн эцэст тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулан ажиллаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:  
Зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээллүүдийг бүрэн мэдээлсэн нь шилэн дансны хуулийн хэрэгжилттэй нийцэж байна.

#### **4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.7.1 Завсрын аудитын талаар**

*Завсрын аудит хийгдээгүй болно.*

##### **4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 01/169 тоот албан бичгээр хариуг ирүүлсэн байна.

*Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	22734.1	2	22734.1	100
Албан шаардлага	1	2490.0	1	2490.0	100
Зөвлөмж	7	69663.7	7	69663.7	100
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>94887.8</b>	<b>10</b>	<b>94887.8</b>	<b>100</b>

#### **4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Сумын ОНХС-гийн зээлийг эргэн төлөлт, олголтыг хэрэгжих төсөл арга хэмжээний шалгаруулалт, гүйцэтгэлийг дараагийн аудитаар шалгах асуудалд оруулах нь зүйтэй байна.

#### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 3399.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2649.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн зөвлөмж өгч, 750.0 мянган төгрөгийн алдааг залруулж ажиллалаа.

Үүнд: ЖДҮДС-гаас олгосон зээлийн 750.0 мянган төгрөгийн хүү тооцож авлагаар тусгаагүй алдааг залруулсан.

Аудитаар нийт 2649.9 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 2 зөвлөмж өглөө.

##### **5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. БМ-тай холбоотой асуудал

#### 1.1. Илрүүлэлт:

БХС-гаас зарцуулсан шатахууны орлого, зарлагыг бараа материалын тодруулга тайланд 2649.9 мянган төгрөгийн шатахууны орлого, зарлагыг тайлагнаагүй байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

БХС-гаас зарцуулсан шатахууны орлого зарлагыг бараа материалын тодруулга тайланд бүрэн тайлагнаж ажиллах.

### 2. ЖДҮДС-гийн зарцуулалтай холбоотой асуудал

#### 2.1 Илрүүлэлт:

ЖДҮДС-гийн зээл олгосон иргэдийн зээлийн эцсийн үлдэгдлийг тооцон баталгаажуулж ажиллаагүй байна.

#### 2.2 Өгсөн зөвлөмж

ЖДҮДС-гийн зээлийн үлдэгдлийг иргэдтэй хагас бүтэн жилд тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зээлийн хүүг тооцож авлагаар тусгаагүй.	1	750.0					1	750.0				
Дүн	1	750.0					1	750.0				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал



---